



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/73/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Булган аймаг 2022 он</p>	<p>Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70642580 Цахим хаяг: Ankhubayrd@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Г.Намчинсүрэн Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

Товчилсон үгийн жагсаалт.....	2
1.Аудитын санал дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт.....	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт.....	18
4.3 Албан шаардлага.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19

### **Товчилсон үгийн жагсаалт**

---

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

## 1.Аудитын санал дүгнэлт



### БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 103.  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

СЭЛЭНГЭ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Ц.УУГАНБАЯР ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сэлэнгэ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлүүд нь санхүүгийн тайланд материаллаг бөгөөд өргөн тархаагүй байна. Үүнд:

- Харилцагч байгууллагуудаас түүвэрлэн тулгалт хийхэд нийт 191.9 сая төгрөгийн гүйлгээг тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй;
- Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй;
- Засаг даргын нөөц хөрөнгөөс байгууллагын урсгал үйл ажиллагааны зардалд 8.3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;
- Цалингийн зардлаас нийт 47.6 сая төгрөгийн ХХОАТ, НДШ-ийн өглөг дансанд давхар бичилт хийгээгүй шууд зардалд бичсэн зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчин тухай хуулийн 71.2, 73.2 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 04-р сарын 20-ны өдрийн 61-р

D:/bichighereg/2022A4toot

006020182

тушаал, " Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.1, 3.1.2, Булган аймгийн Засаг даргын 2020 оны 09 сарын 29-ний өдрийн А/424 дүгээр захирамжаар баталсан НБББББ-ийн 5.10.5 дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой, үнэн зөв, ангилал, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/Төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>58,241,239.00</u></b>	<b><u>60,866,559.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	2,413,520.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	2,413,520.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	58,241,239.00	58,453,039.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	49,349,239.00	50,038,039.00
35420	Аж ахуйн материал	38,499,239.00	38,499,239.00
35470	Бусад хангамжийн материал	10,850,000.00	11,538,800.00
35600	Мал амьтад	8,892,000.00	8,415,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>990,097,995.27</u></b>	<b><u>779,378,464.18</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	990,097,995.27	779,378,464.18
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	976,313,995.27	763,809,464.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	388,343,728.14	380,167,599.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	(9,409,904.42)	(14,662,435.22)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	533,907,740.00	125,101,740.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(295,161,211.58)	(62,896,430.63)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	229,480,821.00	216,672,811.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(103,271,563.18)	(89,341,001.29)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,674,349.10	18,244,349.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,326,764.83)	(14,237,515.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө	419,477,080.00	329,711,887.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(191,400,278.96)	(124,951,540.21)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	13,784,000.00	15,569,000.00
39301	Програм хангамж	300,000.00	2,400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(300,000.00)	(615,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,784,000.00	13,784,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,048,339,234.27</u></b>	<b><u>840,245,023.18</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,048,339,234.27</u></b>	<b><u>840,245,023.18</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,048,339,234.27	840,245,023.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	458,014,431.00	458,014,431.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	184,759,244.77	(15,599,058.01)
51210	Өмнөх үеийн үр дүн	184,759,244.77	192,495,153.08
51220	Тайлант үеийн үр дүн	-	(208,094,211.09)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	405,565,558.50	397,829,650.19
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,048,339,234.27</u></b>	<b><u>840,245,023.18</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/Төрөгөөр/
			Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>942,906,048.00</b>	<b>466,728,882.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8,073,600.00</b>	<b>38,096,050.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	8,073,600.00	38,096,050.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,073,600.00	38,096,050.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	311,600.00	239,050.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,762,000.00	37,857,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>934,832,448.00</b>	<b>428,632,832.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	6,000,000.00	-
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	6,000,000.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	320,609,318.00	39,530,635.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	14,721,751.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,820,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	307,789,318.00	24,808,884.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	608,223,130.00	389,102,197.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	608,223,130.00	389,102,197.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>758,010,963.68</b>	<b>523,770,437.62</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>758,010,963.68</b>	<b>523,770,437.62</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	735,774,863.68	520,421,117.62
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	266,432,988.00	255,885,920.00
210101	Үндсэн цалин	174,262,026.00	167,938,654.00
210102	Нэмэгдэл	48,847,262.00	56,857,221.00
210104	Урамшуулал	972,000.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	42,351,700.00	31,090,045.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	31,489,667.00	33,104,979.00
210201	Тэтгэврийн даатгал	20,903,502.71	23,330,898.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,614,364.29	2,510,043.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,125,800.00	2,008,093.00
210204	Ажилгүйдлийн даатгал	531,500.00	502,049.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,314,500.00	4,753,896.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,796,030.00	24,662,300.00
210301	Гэрэл, цахилгаан	6,177,950.00	6,562,300.00
210302	Түлш, халаалт	14,618,080.00	18,100,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,107,170.00	17,106,978.00
210401	Бичиг хэрэг	2,555,200.00	2,682,108.00
210402	Тээвэр, шатахуун	20,588,290.00	11,708,920.00

Сэлэнгэ сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,805,600.00	1,805,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	612,950.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	297,400.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,158,080.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>204,000.00</b>	<b>600,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	204,000.00	600,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,147,800.00</b>	<b>11,561,600.00</b>
210604	Урсгал засвар	7,147,800.00	11,561,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,213,100.00</b>	<b>2,717,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,213,100.00	2,717,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>38,535,599.00</b>	<b>34,517,855.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,105,699.00	33,411,955.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	418,800.00	418,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	402,800.00	402,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	215,300.00	215,300.00
210807	Газрын төлбөр	69,000.00	69,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>342,848,509.68</b>	<b>140,264,185.62</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	302,721,674.00	38,473,770.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	576,550.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,926,835.68	101,213,865.62
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>22,236,100.00</b>	<b>3,349,320.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>22,236,100.00</b>	<b>925,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,041,100.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,195,000.00	925,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>2,424,320.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,424,320.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>184,895,084.32</u></b>	<b><u>(57,041,555.62)</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>102,571,900.00</b>	<b>151,052,655.47</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	55,000.00	150,755,655.47
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	102,516,900.00	297,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(102,571,900.00)</b>	<b>(151,052,655.47)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>82,323,184.32</u></b>	<b><u>(208,094,211.09)</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Б у с а д	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	444,230,431.00	405,565,558.50	15,821,113.45		865,617,102.95
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	444,230,431.00	405,565,558.50	15,821,113.45	-	865,617,102.95
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	458,014,431.00	405,565,558.50	184,759,244.77	-	1,048,339,234.27
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	458,014,431.00	405,565,558.50	184,759,244.77	-	1,048,339,234.27
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	7,735,908.31		7,735,908.31
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	458,014,431.00	405,565,558.50	192,495,153.08	-	1,056,075,142.58
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(7,735,908.31)	-		(7,735,908.31)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(208,094,211.09)		(208,094,211.09)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	458,014,431.00	397,829,650.19	(15,599,058.01)	-	840,245,023.18

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>935,144,048.00</b>	<b>426,458,362.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>311,600.00</b>	<b>239,050.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	311,600.00	239,050.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	311,600.00	239,050.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	311,600.00	239,050.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>934,832,448.00</b>	<b>426,219,312.00</b>

<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	6,000,000.00	-
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	6,000,000.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	320,609,318.00	37,117,115.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	12,308,231.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,820,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	307,789,318.00	24,808,884.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	608,223,130.00	389,102,197.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	608,223,130.00	389,102,197.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>718,361,668.00</b>	<b>422,208,372.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>718,361,668.00</b>	<b>422,208,372.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>696,600,568.00</b>	<b>419,784,052.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	266,697,700.00	255,885,920.00
210101	Үндсэн цалин	166,766,200.00	167,938,654.00
210102	Нэмэгдэл	57,238,300.00	56,857,221.00
210104	Урамшуулал	972,000.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	41,721,200.00	31,090,045.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,215,700.00	33,104,979.00
210201	Тэтгэврийн даатгал	22,586,700.00	23,330,898.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,657,200.00	2,510,043.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,125,800.00	2,008,093.00
210204	Ажилгүйдлийн даатгал	531,500.00	502,049.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,314,500.00	4,753,896.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,796,030.00	24,662,300.00
210301	Гэрэл, цахилгаан	6,177,950.00	6,562,300.00
210302	Түлш, халаалт	14,618,080.00	18,100,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,963,020.00	17,967,348.00
210401	Бичиг хэрэг	2,570,820.00	2,352,648.00
210402	Тээвэр, шатахуун	17,586,600.00	10,809,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,805,600.00	1,805,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	600,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,147,800.00	11,552,700.00
210604	Урсгал засвар	7,147,800.00	11,552,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,213,100.00	2,717,300.00
210702	Дотоод албан томилолт	2,213,100.00	2,717,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	37,957,546.00	35,809,495.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,527,646.00	34,703,595.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-

210803	Даатгалын үйлчилгээ	418,800.00	418,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	402,800.00	402,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	215,300.00	215,300.00
210807	Газрын төлбөр	69,000.00	69,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>306,009,672.00</b>	<b>37,484,010.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	305,809,672.00	36,834,010.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	650,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>21,761,100.00</b>	<b>2,424,320.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,761,100.00</b>	<b>-</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,041,100.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	720,000.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>2,424,320.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,424,320.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>216,782,380.00</b>	<b>4,249,990.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>218,098,000.00</b>	<b>4,249,990.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>218,098,000.00</b>	<b>4,249,990.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>218,098,000.00</b>	<b>4,249,990.00</b>
222001	Тоног төхөөрөмж	190,098,000.00	2,149,990.00
223001	Бусад хөрөнгө	28,000,000.00	2,100,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(218,098,000.00)</b>	<b>(4,249,990.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(1,315,620.00)</b>	<b>-</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	392,997,200.00	389330947.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	392997200.00	389330947.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	392997200.00	389330947.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	258049700.00	255885920.00
210101	Үндсэн цалин	169090200.00	167938654.00
210102	Нэмэгдэл	57238500.00	56857221.00
210105	Гэрээт ажлын хөлс	31721000.00	31090045.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	34523000.00	33104979.00
210201	Тэтгэврийн даатгал	24294000.00	23330898.00
210202	Тэтгэмжийн даатгал	2557200.00	2510043.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2045800.00	2008093.00

210204	Ажилгүйдлийн даатгал	511500.00	502049.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5114500.00	4753896.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>24662300.00</b>	<b>24662300.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	6562300.00	6562300.00
210302	Түлш, халаалт	18100000.00	18100000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18039100.00</b>	<b>17967848.00</b>
210401	Бичиг хэрэг	2424400.00	2352648.00
210402	Тээвэр, шатахуун	10809100.00	10809600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,805,600.00	1,805,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>600,000.00</b>	<b>600,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,152,700.00</b>	<b>13,152,700.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,600,000.00	1,600,000.00
210604	Урсгал засвар	11,552,700.00	11,552,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,730,500.00</b>	<b>2,717,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,730,500.00	2,717,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,205,900.00</b>	<b>3,205,900.00</b>
210803	Даатгалын үйлчилгээ	418,800.00	418,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	402,800.00	402,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	215,300.00	215,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,100,000.00	2,100,000.00
210807	Газрын төлбөр	69,000.00	69,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>38,034,000.00</b>	<b>38,034,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,384,000.00	37,384,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	650,000.00	650,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>381,692,300.00</b>	<b>389,330,447.00</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>381,392,300.00</b>	<b>389,091,397.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	381,392,300.00	389,091,397.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>300,000.00</b>	<b>239,050.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	239,050.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

			/ төгрөгөөр /
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>320,609,318.00</b>	<b>34,703,595.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>292,609,318.00</b>	<b>34,703,595.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	291,889,318.00	34,703,595.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	972,000.00	-
210104	Урамшуулал	972,000.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,580,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,580,000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	13,827,646.00	34,703,595.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,827,646.00	34,703,595.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	274,509,672.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	274,509,672.00	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	720,000.00	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	720,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	720,000.00	
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>28,000,000.00</b>	-
2200	Дотоод эх үүсвэрээр	28,000,000.00	-
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,000,000.00	
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>277,597,318.00</b>	<b>37,117,115.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>277,597,318.00</b>	<b>37,117,115.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		- 12,308,231.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,114,286.00	24,808,884.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	273,483,032.00	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03/03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сэлэнгэ сумын ЗДТГ нь төр засгийн бодлого шийдвэрийг сурталчлах, таниулах замаар төрийн үйлчилгээг жигд шуурхай хүргэх, төр нийгмийн ажилд иргэдийг өргөнөөр оролцуулах, тэдний үйл ажиллагааг идэвхижүүлэхэд оршино гэж зорилтоо тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.Үүнд:

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль -Хүчингүй болж, шинэчлэн найруулагдсан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журмын дагуу Байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузель сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардал 556,305.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,344.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 6,258.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сэлэнгэ сумын ЗДТГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 210,507.7 мянган төгрөгөөр буюу 20,1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	
Авлага	0	2,413.50	2,413.50
Урьдчилгаа	0	0	
Бараа материал Үндсэн хөрөнгө	58,241.20	58,453.00	211,8

<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,048,339.20</b>	<b>837,831.50</b>	<b>(210,507.70)</b>
<b>Өр төлбөр</b>	-	-	-
<b>Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/</b>	1,048,339.20	840,245.00	(208,094.20)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,048,339.20</b>	<b>837,831.50</b>	<b>(210,507.70)</b>

Авлага дансны үлдэгдэл 2,413.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нэмэлт санхүүжилтийн төрөөс даасан усны төлбөр оны сүүлд орж ирж төсөвт төвлөрсөн нь шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 58,453.0 мянган төгрөг болж 211.8 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан бараа материал 99.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 112.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материал нэмэгдсэн. Өмнөх онуудад бусад хангамжийн материалын дансанд 31,000.0 мянган төгрөгийн өртөгтэй “Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө” гэх мэтийн материал бүртгэснээс бараа материалын үлдэгдэл нөөц ихэссэн байна. Энэ нь бараа материалын нөөц үүсгэсэн илэрхийлэгдэж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 837,831.5 мянган төгрөг болж 210,507.7 мянган төгрөгөөр буурсан нь аймгийн ИТХ-ын тогтоолоор хөрөнгө актлах буюу шилжүүлснээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 4,249.9 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 37,000.0 мянган төгрөгийн 41,249.9 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 367,265.2 мянган төгрөг, акталсан 191,870.1 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 458,014.4 мянган төгрөг өөрчлөлтгүй байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 478,777.0 мянган төгрөгөөр буюу 49.2 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 296,153.2 мянган төгрөгөөр буюу 58.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж, бараа үйлчилгээний бусад зардлууд их хэмжээгээр багассанаар ихээхэн өөрчлөлт гарсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг 428,300.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс хэмнэлтийн горим хэрэгжүүлж 35,400.0 мянган төгрөгөөр бууруулан 392,997.2 мянган төгрөгөөр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 381,392.3 мянган төгрөгийн төсөв баталснаас мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 11,304.9 мянган төгрөгийг оны эхний үлдэгдлээс, 300.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 389,091.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 239.0 мянган төгрөг, оны эхний үлдэгдлээс 11,304.9 мянган төгрөг нийт мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 400,635.3 мянган төгрөгийг зарцуулж 10.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс 23,200.0, аймгийн ИТХ -аас 300.0, стастиктикийн хэлтсээс 700.0, “Булган Мээж” ХХК-иас цэвэр усны төлбөрийн 5,300.0, ГБХЗХГазраас 500.0, иргэд, ААНБ-аас хандиваар 7,100.0 мянган төгрөг нийт 37,100.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

Сэлэнгэ сумын ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 112 мэдээлэл оруулахаас 109 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, таван сая төгрөгөөс дээш 3 удаагийн 24,573.0 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийлээ. Үүнд:

- Таван сая төгрөгөөс дээш 3 удаагийн 24,573.0 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дэх заалттай нийцээгүй;
- Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.
- Байгууллагын дотоод хяналтын журмыг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй, дотоод хяналтын ажил төлөвлөөгүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах журам”-тай нийцээгүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар нийт 4,392.0 мянган төгрөгийн зөрчилд 1,346.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 200.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 330.2 мянган төгрөгийн 2,845.2 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлснээс шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дахь заалт, эд хөрөнгийн тооллогыг бүрэн хийх гэсэн 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчилд хүргүүлсэн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллах, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг зохион байгуулах шаардлагатай байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 31,961.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 10,500.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,385.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11,898.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 6,177.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

### **4.1 Залруулсан алдаа**

Залруулсан алдаа байхгүй.

## 4.2 Төлбөрийн акт

- Сум хөгжүүлэх сангийн программын хөгжүүлэлтийн зардал 100.0 мянган төгрөгийг засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас давхардуулан гаргаж "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.1 дэх заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн ба зохистой батламж мэдэгдэлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.
- Цалингийн зардлаас 847.5 төгрөгийг шууд зардалд бичиж зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 14.2-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө" гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.
- Шатахууны зардлаас 507,100.00 төгрөгийг нярав орлогод аваагүй, шатахууны тооцоо бодохгүйгээр зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 13.1-д " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн нь нийцсэн ба зохистой батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

## 4.3 Албан шаардлага

- Сэлэнгэ сумын Засаг даргын газар нь 2021 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 3 удаагийн худалдан авалтын 24,573,000.00 төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.
- Тайлант онд аж ахуйн нэгж байгууллага, хувь хүн, ажиллагсадтай авлага, өглөгийн тооцоо үүсгэх 191,914,164.00 төгрөгийн ажил гүйлгээг хийснээс тооцоо нийлж тооцооны үлдэгдлийг баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.
- Тайлант онд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн төсвийн хэмнэлт үүсгээгүй нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.
- Тайлант онд бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг хийгээгүй нь ННБ-ийн тухай хуулийн 4.1.2-д " Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.2-д "бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх ", 72.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч

хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан тооллогын комисс томилж байгуулна” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын оршин байх батламж мэдэгдэлийн хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

- Цалингийн зардлаас цалингийн урьдчилгааг цалингийн өглөг дансанд давхар бичилт хийгээгүй шууд зардалд 47,603,702.00 төгрөгийг бичсэн дансны бичилтийн алдаа илэрсэн нь НББ-ийн тухай хуулийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 14.2-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө”, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Засаг даргын нөөц хөрөнгөөс байгууллагын урсгал үйл ажиллагааны зардалд 8,319,900.00 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 04-р сарын 20-ны өдрийн 61-р тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалатын нийтлэг журам"-ын 1.1, 3.1.2, Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах ” гэсэн заалтыг зөрчсөн байна. бүрэн нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ сумын ЗДТГ	9	273,865.4	0	0.00	3	1,454.5	6	273,865,4		